

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/14/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот  
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Ахлах аудитор: Т.Намжил  
Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
3. Аудитын тайлан .....	2
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ТАРИАЛАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Н.ХАДААХҮҮ ТАНАА

додл. од. дс № УВА-2022/14/НА-СТА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ

0200200276

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>34,476,335.00</b>	<b>113,749,535.00</b>
<b>27</b>	<b>Авлага</b>		<b>11,490,280.00</b>
	Бусад авлага		11,490,280.00
	Байгууллагаас авах авлага		11,490,280.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>34,476,335.00</b>	<b>102,259,255.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>		
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>34,476,335.00</b>	<b>102,259,255.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,679,400.00	1,770,200.00
35420	Аж ахуйн материал	25,024,035.00	25,024,035.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,026,000.00	3,863,400.00
35440	Түлш, шатах тослох материал	1,352,900.00	
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	4,394,000.00	71,601,620.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>816,972,896.88</b>	<b>1,297,379,373.02</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>816,972,896.88</b>	<b>1,297,379,373.02</b>
39100	Газар		
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>779,559,979.93</b>	<b>1,260,239,373.02</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	411,196,619.00	422,324,767.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	- 80,203,472.40	- 108,117,806.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	119,527,220.00	290,984,920.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 55,642,847.25	- 64,695,205.86
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	138,419,016.00	163,229,936.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 98,884,159.88	- 113,297,898.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,662,772.00	64,962,772.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 36,045,765.00	- 39,319,160.36
39209	Зам, гүүрийн байгууламж		194,696,506.40
39210	Хуримтлагдсан элэгдэл		-
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		
39214	Бусад үндсэн хөрөнгө	441,934,772.50	596,826,795.50

39215	Хуримтлагдсан элэгдэл	-107,460,702.04	- 147,412,779.06
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	56,527.00	56,527.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>37,412,916.95</b>	<b>37,140,000.00</b>
39301	Програм хангамж	2,020,000.00	2,020,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	- 1,297,083.05	- 1,570,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	60,690,000.00	60,690,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	- 24,000,000.00	- 24,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>851,449,231.88</b>	<b>1,411,128,908.02</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,062,006.00</b>	<b>7,462,180.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,062,006.00</b>	<b>7,462,180.00</b>
	Ажиллагчдтай холбоотой өглөг	1,062,006.00	47,900.00
	Байгууллагад төлөх өглөг		7,414,280.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>850,387,225.88</b>	<b>1,403,666,728.02</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>850,387,225.88</b>	<b>1,403,666,728.02</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	327,375,075.15	327,375,075.15
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>186,991,531.00</b>	<b>758,836,807.14</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	199,631,814.58	205,557,305.00
51220	Тайлант үеийн үр дүн	- 12,640,283.58	553,279,502.14
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	336,020,619.73	317,454,845.73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>851,449,231.88</b>	<b>1,411,128,908.02</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>611,086,613.00</b>	<b>1,191,661,085.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>114,450,000.00</b>	<b>590,894,615.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>114,450,000.00</b>	<b>590,894,615.40</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>114,450,000.00</b>	<b>590,894,615.40</b>
1200042	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	514,080.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	113,790,000.00	590,380,535.40
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	113,790,000.00	559,929,449.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал		30,451,086.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>496,636,613.00</b>	<b>600,766,470.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>87,941,613.00</b>	<b>52,308,070.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив	6,058,472.00	11,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,780,000.00	24,293,097.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,707,641.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,395,500.00	17,014,973.00
	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>408,695,000.00</b>	<b>548,458,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага /	408,695,000.00	548,458,400.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>559,816,130.39</b>	<b>637,992,842.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>559,816,130.39</b>	<b>637,992,842.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>512,170,841.39</b>	<b>527,433,870.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>263,259,410.00</b>	<b>274,529,301.00</b>
210101	Үндсэн цалин	217,542,843.00	231,033,357.00
210102	Нэмэгдэл		
210104	Урамшуулал	275,000.00	1,595,000.00
210105	Гэрээт цалин	45,441,567.00	41,900,944.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,326,903.00</b>	<b>34,741,031.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,905,127.00	24,581,572.00

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	2,563,326.00	2,729,345.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,050,654.00	2,183,475.00
210204	Ажилгүйдлийн даатгал	437,078.00	476,969.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,370,718.00	4,769,670.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,318,465.00</b>	<b>28,680,222.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,307,450.00	4,464,169.00
210302	Түлш, халаалт	19,011,015.00	24,216,053.00
210303	Цэвэр, бохир ус		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,473,347.00</b>	<b>21,824,775.00</b>
210401	Бичиг хэрэг	3,540,300.00	3,371,000.00
210402	Тээвэр, шатахуун	19,028,597.00	16,565,355.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,675,000.00	1,536,920.00
210405	Хог хаягдал устгах цэвэрлэх	200,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	434,900.00	351,500.00
210408	Бараа материал акталсны зардал	1,594,550.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>500,000.00</b>	<b>4,354,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3,937,500.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	416,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,036,793.00</b>	<b>8,163,600.00</b>
<b>210603</b>	<b>Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл</b>	<b>-</b>	<b>390,000.00</b>
210604	Урсгал засвар	2,036,793.00	7,773,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>912,000.00</b>	<b>1,834,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	912,000.00	1,834,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,583,632.00</b>	<b>1,587,814.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	433,464.00	408,032.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	160,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	153,750.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	239,510.00	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	97,282.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	387,000.00	304,500.00
210807	Газрын төлбөр	209,908.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>163,760,291.39</b>	<b>151,719,128.34</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,016,945.00	52,798,396.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	416,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,743,346.39	98,504,232.34
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,645,289.00</b>	<b>110,558,971.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>47,645,289.00</b>	<b>110,558,971.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>47,645,289.00</b>	<b>40,748,300.00</b>

**Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,043,000.00	40,748,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	11,653,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	26,554,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,043,000.00	2,540,000.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	46,602,289.00	69,810,671.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,602,289.00	69,810,671.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	51,270,482.61	553,668,243.06
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	388,740.92
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		-388,740.92
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>51,270,482.61</b>	<b>553,279,502.14</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>497,296,613.00</b>	<b>601,280,550.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>660,000.00</b>	<b>514,080.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>660,000.00</b>	<b>514,080.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>660,000.00</b>	<b>514,080.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	514,080.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>496,636,613.00</b>	<b>600,766,470.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>87,941,613.00</b>	<b>52,308,070.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	6,058,472.00	11,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,780,000.00	24,293,097.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,707,641.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,395,500.00	17,014,973.00
	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>408,695,000.00</b>	<b>548,458,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / орон нутгийн /	408,695,000.00	548,458,400.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>435,946,613.00</b>	<b>576,230,550.00</b>

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>435,946,613.00</b>	<b>576,230,550.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>387,914,324.00</b>	<b>465,671,579.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>262,150,958.00</b>	<b>275,494,087.00</b>
210101	Үндсэн цалин	216,434,391.00	231,998,143.00
210102	Нэмэгдэл	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	275,000.00	1,595,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	45,441,567.00	41,900,944.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,229,684.00</b>	<b>34,790,351.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,807,908.00	24,630,892.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,563,326.00	2,729,345.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,050,654.00	2,183,475.00
210204	Ажилгүйдлийн даатгал	437,078.00	476,969.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,370,718.00	4,769,670.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,068,445.00</b>	<b>28,680,222.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,307,450.00	4,464,169.00
210302	Түлш, халаалт	19,760,995.00	24,216,053.00
210303	Цэвэр, бохир ус	-	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,343,767.00</b>	<b>22,344,325.00</b>
210401	Бичиг хэрэг	3,933,550.00	3,161,800.00
210402	Тээвэр, шатахуун	14,019,917.00	17,294,105.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,675,000.00	1,536,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	296,400.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	418,900.00	351,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>500,000.00</b>	<b>7,416,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		7,000,000.00
210502	Хоол, хүнс	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	416,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,352,793.00</b>	<b>38,082,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,696,000.00	14,500,000.00
210602	Тавилга		8,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		3,000,000.00
210604	Урсгал засвар	2,656,793.00	12,082,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>912,000.00</b>	<b>1,834,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	912,000.00	1,834,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,583,632.00</b>	<b>1,931,314.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	433,464.00	468,032.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	153,750.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	239,510.00	250,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	97,282.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	387,000.00	588,000.00
210807	Газрын төлбөр	209,908.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>40,773,045.00</b>	<b>55,098,780.00</b>

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,744,145.00	54,682,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,900.00	416,500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>48,032,289.00</b>	<b>110,558,971.00</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,430,000.00</b>	<b>40,748,300.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	11,653,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		26,554,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,430,000.00	2,540,000.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох, татаас санхүүжилт	46,602,289.00	69,810,671.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,602,289.00	69,810,671.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>61,350,000.00</b>	<b>25,050,000.00</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>61,350,000.00</b>	<b>25,050,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>61,350,000.00</b>	<b>25,050,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>61,350,000.00</b>	<b>25,050,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>- 61,350,000.00</b>	<b>- 25,050,000.00</b>
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>		
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн				
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,375,075.15	336,020,619.73	186,991,531.00	850,387,225.88
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	327,375,075.15	336,020,619.73	186,991,531.00	850,387,225.88
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	18,565,774.00	18,565,774.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	327,375,075.15	336,020,619.73	205,557,305.00	868,952,999.88
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		- 18,565,774.00	-	- 18,565,774.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
17	Өмчид гарсан өөрчлөлт				-
18	Зарласан ногдол ашиг				-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	553,279,502.14	553,279,502.14
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	327,375,075.15	317,454,845.73	758,836,807.14	1,403,666,728.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	500,595,900.00	462,366,221.00	38,229,679.00	92.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,595,900.00	462,366,221.00	38,229,679.00	92.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	461,554,600.00	423,337,921.00	38,216,679.00	91.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,810,700.00	273,899,087.00	14,911,613.00	94.8

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	242,444,200.00	231,998,143.00	10,446,057.00	95.7
210102	Нэмэгдэл	-	-		
210104	Урамшуулал	-	-		
210105	Гэрээт ажлын хөлс	46,366,500.00	41,900,944.00	4,465,556.00	90.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,989,400.00</b>	<b>34,790,351.00</b>	<b>4,199,049.00</b>	89.2
210201	Тэтгэврийн даатгал	27,436,995.00	24,630,892.00	2,806,103.00	89.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,888,100.00	2,729,345.00	158,755.00	94.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,310,485.00	2,183,475.00	127,010.00	94.5
210204	Ажилгүйдлийн даатгал	577,620.00	476,969.00	100,651.00	82.6
210205	Эрүүл мэндийн даатгал	5,776,200.00	4,769,670.00	1,006,530.00	82.6
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,315,700.00</b>	<b>28,046,721.00</b>	<b>1,268,979.00</b>	95.7
210301	Гэрэл, цахилгаан	5,153,300.00	4,392,283.00	761,017.00	85.2
210302	Түлш, халаалт	24,162,400.00	23,654,438.00	507,962.00	97.9
210303	Цэвэр, бохир ус	-	-		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,301,700.00</b>	<b>19,074,960.00</b>	<b>2,018,740.00</b>	89.5
210401	Бичиг хэрэг	3,170,600.00	3,161,800.00	8,800.00	99.7
210402	Тээвэр, шатахуун	13,596,900.00	14,024,740.00	-427,840.00	103.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,932,800.00	1,536,920.00	395,880.00	79.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	249,900.00	-	249,900.00	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	351,500.00	351,500.00	-	100
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>416,500.00</b>	<b>416,500.00</b>		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-		
210502	Хоол, хүнс	-	-		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	416,500.00	416,500.00		100
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>33,801,100.00</b>	<b>33,498,000.00</b>	<b>303,100.00</b>	99.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,800,000.00	14,500,000.00	300,000.00	98
210602	Тавилга	8,500,000.00	8,500,000.00	-	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл				
210604	Урсгал засвар	10,501,100.00	10,498,000.00	3,100.00	100
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,148,700.00</b>	<b>1,834,000.00</b>	<b>4,314,700.00</b>	29.8

210702	Дотоод албан томилолт	6,148,700.00	1,834,000.00	4,314,700.00	29,8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,889,200.00</b>	<b>1,523,282.00</b>	<b>3,365,918.00</b>	31.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,600,000.00	60,000.00	2,540,000.00	2.3
	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	410,000.00	288,000.00	122,000.00	70.2
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	-	200,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250,000.00	250,000.00	-	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	97,282.00	2,718.00	97,3
210806	Мэдээллийн технологийн зардал	1,089,200.00	588,000.00	501,200.00	54
210807	Газрын төлбөр	240,000.00	240,000.00	-	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,881,600.00	30,255,020.00	7,834,580.00	80,4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,465,000.00	29,838,520.00	7,834,480.00	80,1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,600.00	416,500.00	100.00	100
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,041,300.00</b>	<b>39,028,300.00</b>	<b>13,000.00</b>	100
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>				
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг				
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>				
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,653,400.00		11,653,400.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		11,653,400.00	11,653,400.00	- 100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,554,900.00	26,554,900.00	-	100
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	833,000.00	820,000.00	13,000.00	98.4
	Хөрөнгийн зардал	44,050,000.00	25,050,000.00	19,000,000.00	56.9
	Дотоод эх үүсвэр	44,050,000.00	25,050,000.00	19,000,000.00	56.9
223001	Бусад хөрөнгө	44,050,000.00	25,050,000.00	19,000,000.00	56.9
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>464,395,900.00</b>	<b>548,972,480.00</b>	<b>84,576,580.00</b>	- 118. 2

31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
310001	Улсын төсвөөс санхүүжих				
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	348,235,900.00	548,458,400.00	200,222,500.00	157.5
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		514,080.00	514,080.00	100
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	116,160,000.00			

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		44,053,658.00	-44,053,658.00	
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		44,053,658.00	-44,053,658.00	
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		42,333,658.00	-42,333,658.00	
	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал		1,595,000.00	- 1,595,000.00	
210104	Урамшуулал		1,595,000.00	- 1,595,000.00	
	Байр ашиглалттай холбоотой тогтмол		633,501.00	- 633,501.00	
210301	Гэрэл цахилгаан		71,886.00	- 71,886.00	
210302	Түлш халаалт		561,615.00	- 561,615.00	
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		3,269,365.00	- 3,269,365.00	
210401	Бичиг хэрэг			-	
210402	Тээвэр, шатахуун		3,269,365.00	- 3,269,365.00	
	Нормативт зардал		7,000,000.00	- 7,000,000.00	
210501	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл		7,000,000.00	- 7,000,000.00	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		4,584,000.00	4,584,000.00	
	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		3,000,000.00	- 3,000,000.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл			-	
210604	Урсгал засвар		1,584,000.00	- 1,584,000.00	
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		408,032.00	- 408,032.00	
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		408,032.00	- 408,032.00	
	Бараа үйлчилгээний бусад зардал		24,843,760.00	-24,843,760.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		24,843,760.00	-24,843,760.00	

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,720,000.00	-1,720,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,720,000.00	- 1,720,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,720,000.00	-1,720,000.00	
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>52,308,070.00</b>	<b>-52,308,070.00</b>	
31	Нэмэлт санхүүжилтийн орлого		52,308,070.00	-52,308,070.00	
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		11,000,000.00	11,000,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		24,293,097.00	-24,293,097.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө				
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		17,014,973.00	-17,014,973.00	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тариалан сумын Засаг даргын тамгын газар нь Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ

олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ, мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 547,175.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,471.7 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 637,992.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 6,379.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,103.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тариалан сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 559,679.7 мянган төгрөгөөр буюу 65.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	0	11,490.3	11,490.3
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	34,476.3	102,259.2	67,782.9
Үндсэн хөрөнгө	816,972.9	1,297,379.4	480,406.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>851,449.2</b>	<b>1,411,128.9</b>	<b>559,679.7</b>
Өр төлбөр	1,062.0	7,462.2	6,400.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	850,387.2	1,403,666.7	553,279.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>851,449.2</b>	<b>1,411,128.9</b>	<b>559,679.7</b>

Авлага дансны үлдэгдэл 11,490.2 мянган төгрөг болж 11,490.3 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр орж ирсэн цэвэр усны мөнгө 2,549.2 мянга, арвай тарианы үрийн үнэ 4,865.0 мянга, нийт 7,414.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөн аудитаар илүү шилжүүлсэн шатахууны зардал 1,792.0 мянган төгрөгийг Хязгааргүй прогресс ХХК - аас, 2,284.0 мянган төгрөгийг Ундарга Увс ХХК-аас авах авлага үүсгүүлэн залруулга хийлгэсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 102,259.2 мянган төгрөг болж 67,782.9 мянган төгрөгөөр өссөн нь арвай тарианы үрийн үнэ 17,000.0 мянган төгрөг, чацаргана суулгацын үр 21,280.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан ковид -19 халдвар хамгаалалтын үеийн бэлэн байдлыг хангахад зориулан 7,000.0 мянган төгрөгийн материал худалдан авсан нь голчлон нөлөөлсөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэсэн нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,297,379.4 мянган төгрөг болж 480,406.5 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 48,050.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 531,249.4 мянган хөрөнгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 2,014.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 7,462.2 мянган төгрөг болж 6,400.2 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон цэвэр усны хөнгөлөлт 2,459.2 мянган төгрөг, арвай тарианы үрийн үнэ 4,865.0 төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,403,666.7 мянган төгрөг болж 553,279.5 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь худалдан авсан хөрөнгө болон үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 580,574.5 мянган төгрөгөөр буюу 95 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээж авсан орлого, орон нутгийн төсвөөс санхүүжих орлого байна. Энд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 476,590.5 мянган төгрөгөөр өссөн нь голчлон нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 90,816.9 төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өсөхөд цалин, НДШ, эмийн зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал зэрэг зардлууд голчлон нөлөөлжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 500,595.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 500,595.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 36,200.0 мянган төгрөгөөр бууруулж 464,395.9 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 464,395.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 348,235.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 116,160.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 548,458.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 514.1 мянган төгрөг оруулж, нийт 548,972.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 462,366.2 мянга, хөрөнгийн зардалд 25,050.0 мянга, нийт 487,416.2 мянган төгрөг зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны данснаас 61,556.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 462,366.2 мянган төгрөг буюу 92.4 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив, тусламж 11,000.0 мянга, ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй хөрөнгөөс 24,293.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 17,014.9 мянга, нийт 52,308.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 1595.0 мянган, байр ашиглалттай холбоотой зардалд 633.5 мянга, хангамж, бараа материалын зардалд 3,269.4 мянга, нормативт зардалд 7,000.0 мянга, эд хогшил худалдан авахад 4,584.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 408.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 24,843.7 мянга, нэг удаагийн тэтгэмж 1,720.0 мянга, нийт 44,053.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 8,254.3 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Тариалан сумын Засаг даргын тамгын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 144 мэдээллийг хугацаандаа 6 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна. Мэдээлэх хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй.
2. Аймгийн ОНХС-ын санхүүжилтээр хийгдсэн Шинэ хөдөө төслийн санхүүжилт 17.0 сая төгрөгөөр арвай буудайн үр худалдан авч 5.8 сая төгрөгийн буудайг буцаан авах нөхцөлтэй гэрээ байгуулан иргэдэд олгож, 11.2 сая төгрөгийн арвай буудайг бусад хангамжийн материал дансанд бүртгэсэн үлдэгдэлтэй байна. Арвай буудайн зарцуулалтыг Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгийн зарцуулалт үр дүн нийцлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 348,325.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг залрууллаа.

### 4.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дэх хэсэгт “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчсөн нийт 348,325.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснийг аудитын явцад залруулга хийлгэв. Үүнд:

1. Шатахууны зардалд 4,076.0 мянган төгрөгийг илүү шилжүүлэн үр дүнгийн тайланд зардлаар, материалын тайланд үлдэгдлээр илэрхийлснийг авлага тусгуулан залруулга хийлгэсэн.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Сайжруулсан шороон замын 194,696.5 мянга, орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинэ хөдөө төслийн хүрээнд хийгдсэн Тээл газар тариалангийн чиглэлд Цахилгаан дамжуулах агаарын шугам дэд станцын 70,290.0 мянга, чацаргана жимс жимсгэнэ эх цэцэрлэг байгуулах ажлын 53,901.0 мянга, нийт 318,887.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данс бүртгэлд тусгаагүй байсныг залруулга хийлгэлээ.
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинэ хөдөө төслийн хүрээнд хийгдсэн чацаргана жимс жимсгэний эх цэцэрлэг байгуулах ажлын 25,361.5 мянган төгрөгийн бараа материал данс бүртгэлд тусгаагүй байсныг залруулга хийлгэсэн.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тариалан сумын Засаг даргын тамгын газар	3	348,325.0	3	348,325.0						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Т.НАМЖИЛ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр